

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХАР УС НУУР ОРЧМЫН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/101/СТА-ТШЗ

|   |   |
|---|---|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот<br/>2021 он</p> | <p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br/>Утас: 70433061<br/>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br/>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br/>Утас:70432545<br/>Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn<br/>Ахлах аудитор: Ц.Гантулга<br/>Утас: 70432545<br/>цахим хаяг: Gantulga.TS@audit.gov.mn</p> |
|---|---|

*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

**Товчилсон үгийн жагсаалт**

|                 |  |
|-----------------|--|
| <i>АДБОУС</i>   | <i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>            |
| <i>АОУС</i>     | <i>Аудитын Олон Улсын Стандарт</i>                                 |
| <i>УСНББОУС</i> | <i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i> |
| <i>ТТЗ</i>      | <i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>                                |
|                 | <i>Төсвийн шууд захирагч</i>                                       |
| <i>ТШЗ</i>      |  |
|                 | <i>Байгаль орчин аялал жуулчлалын яам</i>                          |
| <i>БОАЖЯ</i>    |  |

## Агуулга

|   |    |
|---|----|
| 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....   | 4  |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....  | 5  |
| 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....   | 5  |
| 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН.....  | 7  |
| 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....   | 8  |
| 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....  | 9  |
| 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН .....  | 10 |
| 3.АУДИТЫН ТАЙЛАН.....   | 11 |
| 3.1. Ерөнхий зүйл.....  | 11 |
| 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....  | 11 |
| 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....  | 12 |
| 3.4. Материаллаг байдал .....   | 12 |
| 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....   | 12 |
| 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....  | 13 |
| 3.7. Шилэн дансны мэдээлэл.....   | 14 |
| 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....  | 14 |
| 3.9. Аудитын илрүүлэлт.....   | 14 |
| Залруулсан алдаа.....   | 14 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....   | 14 |
| 3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд..... | 14 |

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХАР-УС НУУР ОРЧМЫН УЛСЫН ТУСГАЙ  
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА С.БАТМӨНХ ТАНАА

2021.02.01 № 02/13  
тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Хар-ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Хар-ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хар-ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

021020138

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт   | /Төгрөгөөр/                  |                              |
|------------|---|------------------------------|------------------------------|
|            |   | Эхний үлдэгдэл               | Эцсийн үлдэгдэл              |
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b><u>16,722,210.46</u></b>  | <b><u>13,270,972.06</u></b>  |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 16,722,210.46                | 13,270,972.06                |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>  | 16,722,210.46                | 13,270,972.06                |
| 35470      | Бусад хангамжийн материал   | 16,722,210.46                | 13,270,972.06                |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b><u>553,161,159.29</u></b> | <b><u>593,291,150.06</u></b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 553,161,159.29               | 593,291,150.06               |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>   | 522,993,159.29               | 562,723,150.06               |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц  | 387,232,850.00               | 417,081,757.00               |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл   | -12,315,766.68               | -24,797,360.62               |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл  | 144,861,247.89               | 137,264,692.89               |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл   | -40,538,166.80               | -34,911,670.57               |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 61,640,150.81                | 47,554,550.81                |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл   | -32,585,240.81               | -23,337,825.88               |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 10,515,398.43                | 8,867,518.43                 |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл   | -5,121,818.09                | -4,337,589.85                |
| 39214      | Бусад үндсэн хөрөнгө  | 28,571,100.00                | 51,263,900.00                |
| 39215      | Хуримтлагдсан элэгдэл   | -19,266,595.46               | -11,924,822.15               |
| <b>393</b> | <b>Биет бус хөрөнгө</b>   | 30,168,000.00                | 30,568,000.00                |
| 39301      | Програм хангамж   | 1,050,000.00                 | 400,000.00                   |
| 39303      | Бусад биет бус хөрөнгө  | 30,168,000.00                | 30,168,000.00                |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b><u>569,883,369.75</u></b> | <b><u>606,562,122.12</u></b> |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>569,883,369.75</u></b> | <b><u>606,562,122.12</u></b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 569,883,369.75               | 606,562,122.12               |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 794,074,428.00               | 794,074,428.00               |
| 51101      | Өмч: - төрийн   | 794,074,428.00               | 794,074,428.00               |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | -                            | -230,725,227.40              |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | -                            | -267,403,979.77              |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 00.00                        | 36,678,752.37                |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 43,212,921.52                | 43,212,921.52                |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>569,883,369.75</u></b> | <b><u>606,562,122.12</u></b> |

### 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | /Төгрөгөөр/         |                       |
|------------|----------|---------------------|-----------------------|
|            |          | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>   | <b>388,778,317.52</b> | <b>482,686,607.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>89,473,547.52</b>  | <b>41,652,500.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 89,473,547.52         | 41,652,500.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 4,800,000.00          | 4,898,000.00          |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 4,800,000.00          | 4,898,000.00          |
| 1200017     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө   | 84,561,547.52         | 36,754,500.00         |
| 1200018     | Үнэ төлбөргүй хүлээн авсан-Бараа материал  | 112,000.00            | 00.00                 |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>299,304,770.00</b> | <b>441,034,107.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 279,665,700.00        | 384,175,200.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 279,665,700.00        | 384,175,200.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 19,639,070.00         | 56,858,907.00         |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 12,394,070.00         |                       |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 56,788,907.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 7,245,000.00          | 70,000.00             |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>348,831,663.70</b> | <b>446,007,854.63</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>348,831,663.70</b> | <b>446,007,854.63</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 346,810,680.70        | 429,150,160.63        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 199,607,189.00        | 233,616,806.00        |
| 210101      | Үндсэн цалин   | 162,828,589.00        | 178,165,353.00        |
| 210102      | Нэмэгдэл   | 26,267,600.00         | 40,126,853.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 10,511,000.00         | 15,324,600.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 24,950,900.00         | 31,548,900.00         |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 16,966,700.00         | 22,153,600.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,996,000.00          | 2,348,900.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 1,596,900.00          | 1,879,100.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 399,200.00            | 469,700.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,992,100.00          | 4,697,600.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 29,028,628.00         | 29,169,772.00         |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 23,639,328.00         | 23,530,200.00         |
| 210302      | Түлш, халаалт  | 260,000.00            | 519,700.00            |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 5,129,300.00          | 5,119,872.00          |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 20,576,500.35         | 19,880,125.00         |
| 210401      | Бичиг хэрэг  | 1,211,800.00          | 924,250.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 6,490,170.00          | 17,182,600.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 1,090,600.00          | 1,216,575.00          |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал  | 60,000.00             | 72,000.00             |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 1,879,700.00          | 484,700.00            |
| 210408      | Бараа материал акталсны зардал   | 9,844,230.35          |                       |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>  | 871,200.00            | 871,200.00            |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 871,200.00            | 871,200.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 1,953,900.00          | 1,005,800.00          |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 471,200.00            | 471,200.00            |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 534,600.00            | 534,600.00            |
| 210604      | Урсгал засвар  | 948,100.00            |                       |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 12,546,500.00         | 2,780,900.00          |
| 210702      | Дотоод албан томилолт  | 12,546,500.00         | 2,780,900.00          |

|               |  |                      |                      |
|---------------|--|----------------------|----------------------|
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 19,942,800.00        | 54,991,741.40        |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,479,200.00        | 53,380,241.40        |
| 210802        | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 158,400.00           | 324,000.00           |
| 210803        | Даатгалын үйлчилгээ  | 742,500.00           | 742,500.00           |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар   | 242,900.00           | 219,900.00           |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 33,000.00            | 49,500.00            |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 236,500.00           | 242,000.00           |
| 210807        | Газрын төлбөр  | 50,300.00            | 33,600.00            |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 37,333,063.35        | 55,284,916.23        |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 3,039,600.00         | 1,871,500.00         |
| 210903        | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 34,293,463.35        | 53,413,416.23        |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 2,020,983.00         | 16,857,694.00        |
| <b>2132</b>   | <b>Нэг удаагийн тэтгэмж урамшуулал</b>                               | 1,890,000.00         | 00.00                |
| <b>213209</b> | <b>Нэг удаагийн тэтгэмж урамшуулал</b>                               | 1,890,000.00         | 00.00                |
| <b>2133</b>   | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | 130,983.00           | 16,857,694.00        |
| 213303        | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 130,983.00           | 16,857,694.00        |
| <b>3</b>      | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>39,946,653.82</b> | <b>36,678,752.37</b> |
| 225011        | Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал                           | 126,755.20           |                      |
| <b>5</b>      | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                                       | <b>39,819,898.62</b> | <b>36,678,752.37</b> |

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>  |                       |                       |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>  | <b>304,104,770.00</b> | <b>445,932,107.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>   | <b>4,800,000.00</b>   | <b>4,898,000.00</b>   |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>   | 4,800,000.00          | 4,898,000.00          |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого   | 4,800,000.00          | 4,898,000.00          |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих  | 4,800,000.00          | 4,898,000.00          |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>299,304,770.00</b> | <b>441,034,107.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 279,665,700.00        | 384,175,200.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 279,665,700.00        | 384,175,200.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 19,639,070.00         | 56,858,907.00         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 56,788,907.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 19,639,070.00         | 70,000.00             |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>   | <b>304,104,770.00</b> | <b>445,932,107.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>304,104,770.00</b> | <b>445,932,107.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>302,083,787.00</b> | <b>429,074,413.00</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 199,607,189.00        | 233,616,806.00        |
| 210101      | Үндсэн цалин   | 162,828,589.00        | 178,165,353.00        |
| 210102      | Нэмэгдэл   | 26,754,000.00         | 40,126,853.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 10,024,600.00         | 15,324,600.00         |

|             |  |                     |                      |
|-------------|--|---------------------|----------------------|
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                | 24,950,900.00       | 31,548,900.00        |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 16,966,700.00       | 22,153,600.00        |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,966,000.00        | 2,348,900.00         |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 1,596,900.00        | 1,879,100.00         |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 399,200.00          | 469,700.00           |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 3,992,100.00        | 4,697,600.00         |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                     | 29,028,628.00       | 29,169,772.00        |
| 210301      | Гэрэл, цахилгаан   | 23,639,328.00       | 23,530,200.00        |
| 210302      | Түлш, халаалт  | 260,000.00          | 519,700.00           |
| 210303      | Цэвэр, бохир ус  | 5,129,300.00        | 5,119,872.00         |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                              | 10,732,270.00       | 19,820,125.00        |
| 210401      | Бичиг хэрэг  | 1,211,800.00        | 889,250.00           |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 6,490,170.00        | 17,157,600.00        |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,090,600.00        | 1,216,575.00         |
| 210405      | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 60,000.00           | 72,000.00            |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 1,879,700.00        | 484,700.00           |
| <b>2105</b> | <b>Норматив зардал</b>   | 871,200.00          | 871,200.00           |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 871,200.00          | 871,200.00           |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 1,953,900.00        | 1,005,800.00         |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 471,200.00          | 471,200.00           |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 534,600.00          | 534,600.00           |
| 210604      | Урсгал засвар  | 948,100.00          |                      |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 12,546,500.00       | 2,780,900.00         |
| 210702      | Дотоод албан томилолт  | 12,546,500.00       | 2,780,900.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 19,053,600.00       | 108,329,410.00       |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,590,000.00       | 106,717,910.00       |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 158,400.00          | 324,000.00           |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 742,500.00          | 742,500.00           |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 242,900.00          | 219,900.00           |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 33,000.00           | 49,500.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 236,500.00          | 242,000.00           |
| 210807      | Газрын төлбөр  | 50,300.00           | 33,600.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 3,339,600.00        | 1,931,500.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 3,339,600.00        | 1,931,500.00         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>2,020,983.00</b> | <b>16,857,694.00</b> |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>1,890,000.00</b> | <b>00.00</b>         |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 1,890,000.00        | 00.00                |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | 00.00               | 16,857,694.00        |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 130,983.00          | 16,857,694.00        |

## 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн      | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|------------------------|--|
| C01 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 794,074,428.00                  | 44,455,489.35         | -308,466,446.22        | 530,063,471.13                         |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | <b>794,074,428.00</b>           | <b>44,455,489.35</b>  | <b>-308,466,446.22</b> | 530,063,471.13                         |
| C07 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | -12,629,497.37         | -12,629,497.37                         |
| C08 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>794,074,428.00</b>           | <b>43,212,921.52</b>  | <b>-267,403,979.77</b> | 569,883,369.75                         |
| D01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>794,074,428.00</b>           | <b>43,212,921.52</b>  | <b>-267,403,979.77</b> | 569,883,369.75                         |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | <b>794,074,428.00</b>           | <b>43,212,921.52</b>  | <b>-267,403,979.77</b> | 569,883,369.75                         |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | 36,678,752.37          | 36,678,752.37                          |
| D09 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | <b>794,074,428.00</b>           | <b>43,212,921.52</b>  | <b>-230,725,227.40</b> | 606,562,122.12                         |

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Дансны код  | Үзүүлэлт  | Төгрөгөөр             |                |
|-------------|---|-----------------------|----------------|
|             |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| <b>1</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b> |                       |                |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                | 388,975,200.00        | 389,073,200.00 |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                    | 388,975,200.00        | 389,073,200.00 |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                  | 388,975,200.00        | 372,285,506.00 |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                | 234,879,900.00        | 233,616,806.00 |
| 210101      | Үндсэн цалин  | 178,288,300.00        | 178,165,353.00 |
| 210102      | Нэмэгдэл  | 41,267,000.00         | 40,126,853.00  |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                   | 15,324,600.00         | 15,324,600.00  |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 31,708,900.00         | 31,548,900.00  |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                      | 22,313,600.00         | 22,153,600.00  |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                      | 2,348,900.00          | 2,348,900.00   |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                       | 1,879,100.00          | 1,879,100.00   |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                    | 469,700.00            | 469,700.00     |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                   | 4,697,600.00          | 4,697,600.00   |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>        | 29,179,200.00         | 29,169,772.00  |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 23,530,200.00         | 23,530,200.00  |
| 210302      | Түлш, халаалт   | 519,700.00            | 519,700.00     |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 5,129,300.00          | 5,119,872.00   |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>                 | 19,921,000.00         | 19,820,125.00  |

|               |  |                |                |
|---------------|--|----------------|----------------|
| 210401        | Бичиг хэрэг  | 898,200.00     | 889,250.00     |
| 210402        | Тээвэр, шатахуун   | 17,157,600.00  | 17,157,600.00  |
| 210403        | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 1,308,500.00   | 1,216,575.00   |
| 210405        | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 72,000.00      | 72,000.00      |
| 210406        | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 484,700.00     | 484,700.00     |
| <b>2105</b>   | <b>Нормативд зардал</b>  | 871,200.00     | 871,200.00     |
| 210503        | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 871,200.00     | 871,200.00     |
| <b>2106</b>   | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | 1,005,800.00   | 1,005,800.00   |
| 210601        | Багаж, техник, хэрэгсэл  | 471,200.00     | 471,200.00     |
| 210603        | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 534,600.00     | 534,600.00     |
| <b>2107</b>   | <b>Томилолт, зочны зардал</b>  | 2,780,900.00   | 2,780,900.00   |
| 210702        | Дотоод албан томилолт  | 2,780,900.00   | 2,780,900.00   |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 66,696,800.00  | 51,540,503.00  |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 65,077,300.00  | 49,929,003.00  |
| 210802        | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 324,000.00     | 324,000.00     |
| 210803        | Даатгалын үйлчилгээ  | 742,500.00     | 742,500.00     |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар   | 219,900.00     | 219,900.00     |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношилгоо  | 49,500.00      | 49,500.00      |
| 210806        | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 250,000.00     | 242,000.00     |
| 210807        | Газрын төлбөр  | 33,600.00      | 33,600.00      |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 1931500.00     | 1931500.00     |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 1,931,500.00   | 1,931,500.00   |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 0.00           | 0.00           |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 388,975,200.00 | 389,073,200.00 |
| <b>1310</b>   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                       | 384,175,200.00 | 384,175,200.00 |
| 131001        | Улсын төсвөөс санхүүжих  | 384,175,200.00 | 384,175,200.00 |
| 132007        | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих                              |                |                |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | 4,800,000.00   | 4,898,000.00   |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 4,800,000.00   | 4,898,000.00   |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>   | 22.00          | 22.00          |
| 620001        | Удирдах ажилтан  | 01.00          | 01.00          |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан  | 18.00          | 18.00          |
| 620003        | Үйлчлэх ажилтан  | 03.00          | 03.00          |

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он             | Гүйцэтгэл            |
|-------------|--|----------------------|----------------------|
|             | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                             | <b>19,639,070.00</b> | <b>56,858,907.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>19,639,070.00</b> | <b>56,858,907.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 19,639,070.00        | 56,788,907.00        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 19,639,070.00        | 56,788,907.00        |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж |                      | 56,788,907.00        |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                 | <b>00.00</b>         | <b>70,000.00</b>     |

|             |  |                      |               |
|-------------|--|----------------------|---------------|
| 213303      | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг  | 00.00                | 70,000.00     |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>19,639,070.00</b> | 56858907.00   |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>19,639,070.00</b> | 56,858,907.00 |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |                      | 56,788,907.00 |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 19,639,070.00        | 70,000.00     |
| <b>IV</b>   | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>  |                      |               |

### 3.АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга С.Батмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 01 дугаар сарын 31-ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Гантулга хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны “Монгол Алтайн нурууны мөнх цас, мөсөн гол, түүнд зохицон шүтэж амьдрах биологийн төрөл зүйлүүд, ховор амьтан, ургамлыг хамгаалах, амьдрах орчныг хадгалан үлдээх, улмаар даян дэлхийд гарч буй байгаль орчны өөрчлөлтийг хянах, мэдээлэл солилцох, судалгаа шинжилгээ явуулах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх оновчтой менежментийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх
- Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах
- Харьяа яамны сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны хяналт үнэлгээ, шинжилгээний газар болон аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин Санхүү төрийн сангийн хэлтсийн төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд БАГА гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 348950.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3489.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 390923.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3909.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36678.8 төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Балансын үзүүлэлт                          | Эхний үлдэгдэл  | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт       |
|--|-----------------|-----------------|----------------|
| АВЛАГА                                     | 0               | 0.00            | 0              |
| БАРАА МАТЕРИАЛ                             | 16722.2         | 13270.9         | (3451.3)       |
| ҮНДСЭН ХӨРӨНГӨ                             | 553161.1        | 593291.1        | 40129.9        |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                  | <b>569883.3</b> | <b>606562.1</b> | <b>36678.8</b> |
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                  | 0               | 0               | 0              |
| ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                   | 569883.3        | 606562.1        | 36678.8        |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> | <b>569883.3</b> | <b>606562.1</b> | <b>36678.8</b> |

Өнгөрсөн оны бараа материалын дансны үлдэгдэл 13270.9 мянган төгрөг болж 3451.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд ашиглалтын хугацаа дууссан нормын хувцас, гутал, бусад бараа материал зарлагдаж данснаас хассан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 553161.1 мянган төгрөг, оны эцэст 593291.1 мянган төгрөг болж 40129.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ өсөлт нь Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон харьяа яамны хооронд байгуулсан гэрээний дагуу Байгаль хамгаалагчийн ажлын байр хяналтын цэг байгуулах, эко нойл, хогийн цэг байгуулах, БОАЖЯ-наас мотоцикл-11 ширхэг зэрэг хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 794074.4 мянган төгрөг байсан нь тайлант онд өөрчлөлтгүй байна.

Хар ус нуур орчмын улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 93908.2 мянган төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна.

Дээрх үзүүлэлт нь 104509.5 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилт 37216.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 16836.4 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагаа болон үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 97176.2 мянган төгрөгөөр буюу 27.9 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 18.1 хувиар, тогтмол зардал 141,1 мянган төгрөг буюу 0,4 хувиар, хангамж бараа материалын зардал 756.4 мянган төгрөг буюу 3.7 хувиар буурсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 35048.9 мянган төгрөг буюу 175.7 хувиар өссөн, эд хогшил, урсгал засварын зардал 930.1 мянган төгрөг буюу 45.8 хувиар, дотоод албан томилолтын зардал 9765.6 мянган төгрөг буюу 77.8 мянган хувиар, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал 1108.1 мянган төгрөг буюу 36.5 хувиар буурсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 388975.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 388975.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл:**

Тайлант онд 388975.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 384175.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4800.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 384175.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 4898.0 мянган төгрөг, нийт 389073.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 372285.5 мянган төгрөгийг зарцуулж 16787.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 372285.5 мянган төгрөг буюу 95.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1423.1 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 9.5 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 100.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 15156.3 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 98.0 мянган төгрөг буюу 2.0 хувиар давуулж биелүүлсэн орлогыг мөн төвлөрүүлсэн байна.

### **Нэмэлт санхүүжилт :**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт тайлангийн тайлангаар Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг болон харьяа яамны хооронд байгуулсан 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан санхүүжилтийн 83342079, 83342284 тоот гэрээний дагуу 56788.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 70.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

Дээрх санхүүжилтээр байгаль хамгаалагчийн ажлын байр хяналтын цэг байгуулахад 29848.7 , эко нойл, хогийн цэг байгуулахад 26940.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, 4 мэдээлэл хугацаа нь болоогүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 22 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илэрсэнгүй.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Үгүй.

### **3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал хандуулахуйц асуудал байхгүй болно.

## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР